



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 5/20

Жаргалтхаан сум

А.Мөнх-Амгаланг ажилд түр томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2, 64 дүгээр зүйлийн 64.1 дэхь хэсэг, Улсын Их Хурлын 2007 оны “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоолын 1 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Чулуут багийн Засаг даргаар Алтангэрэлийн Мөнх-Амгаланг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс тус багийн Засаг даргын сонгууль болж, Засаг дарга томилогдтол туршилтын хугацаагаар түр томилсугай.

2.Багийн Засаг даргаар түр томилогдсон А.Мөнх-Амгалангийн үндсэн цалинг 1458000 (нэг сая дөрвөн зуун тавин найман мянга) төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 30 хувь, орон нутагт ажилласны нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тус тус тооцож цалинжуулахыг нягтлан бодогч Т.Энхсайханд зөвшөөрсүгэй.

3.Сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажиллахыг А.Мөнх-Амгаланд үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГАНБАТ